



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮН, БОЛОВСРОЛЫН
САЙД П.НАРАНБАЯР ТАНАА

2025.05.06 № 20

Засгийн газрын тогтоолын
хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолын хүрээнд орон нутгийн их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудад сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт үзүүлж эхэлсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2020–2024, 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Бүх шатны боловсролын тэгш хүртээмж, чанарыг сайжруулах”, “Боловсролын санхүүгийн дэмжлэгийг сайжруулах”, “Дээд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх”, Монгол Улсын хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ийн “Орон нутгийн боловсрол, эдийн засгийн төвлөрлийг сааруулах”, Боловсролын ерөнхий хууль болон Дээд боловсролын тухай хуулийн “Иргэдэд тэгш хүртээмжтэй боловсрол олгох”, Боловсролын салбарын дунд хугацааны бодлого (2021–2030)-ийн “Орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллагыг дэмжих”, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын “Хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн тогтвортой байдлыг дэмжих” зэрэг бодлогын баримт бичигт туссан бодлогын зохицуулалтын хэрэгжилтийг хангаж боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах, орон нутгийн их, дээд сургуулийг дэмжих бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан зохицуулалт байсан.

Гэвч Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам”-д дээрх төлбөрийн хөнгөлөлтийн зохицуулалтыг тусгахдаа хөнгөлөлт олгох нөхцөлд “амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн байх” гэсэн халамжийн бодлогын шалгуур нэмсэн нь дээрх Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүд болон Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийн үндсэн зорилго, зарчим түүний хүрээнд зохицуулсан зохицуулалттай зөрчилдөж байна. Тухайлбал,

1. Монгол Улсын Боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хуульд “тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх”, “дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг дэмжсэн байх” зэрэг зарчимтай. Гэтэл дээрх зохицуулалтаар зөвхөн ядуурлын шугамаас доогуур орлоготой өрхийн суралцагчийг хөнгөлөлтөд хамруулж бага, дунд орлоготой өрхийн хүүхдүүд хөнгөлөлт авах боломжийг орлогын нэг шалгуураар хязгаарласан нь ялгаварлал, тэгш бус байдлыг үүсгэсэн байна.

2. Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолын 2 дахь заалтын зорилгыг саармагжуулж, боловсролын хүртээмжийг алдагдуулсан, хөдөө орон нутгийн их, дээд сургуулиудын өрсөлдөх чадвар, элсэлтийг бууруулсан, төвлөрлийг сааруулах бус хот руу

2025000931

чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг дэмжсэн, бодлогын зорилго зорилтын уялдаа холбоо, залгамж байдлыг бууруулсан зохицуулалт болсон.

Үүнээс үүдэн улсын хэмжээнд 2022-2023, 2023-2024 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хэвийн хамрагдаж байсан орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллагын олон суралцагчид 2024-2025 оны хичээлийн жилд уг хөнгөлөлтөд хамрагдаж чадахгүй нөхцөл үүссэн талаарх гомдлыг орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид, тэдний эцэг эхчүүд болон сургалтын байгууллагаас Улсын Их Хурлын гишүүний нэр дээр ирүүлээд байна.

Тухайлбал “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль ба 2022-2023 оны хичээлийн жилд 224 оюутан 268,8 сая төгрөг, 2023-2024 оны хичээлийн жилд 246 оюутан 409,6 сая төгрөгийн төлбөрийн хөнгөлөлтийг хэвийн авч байсан бол 2024-2025 оны хичээлийн жилд элссэн 223 суралцагчийн 432,5 сая төгрөгийн санхүүжилтийг журмын дээрх заалттай холбоотойгоор санхүүжүүлээгүй байна.

Гэтэл Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоол өнөөдрийг хүртэл хүчинтэй хэвээр байсаар байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн бүрэн эрхийнхээ хүрээнд дараах чиглэлээр асуулга тавьж байна. Үүнд:

1. Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль болон Боловсролын салбарын дунд хугацааны бодлогод баримталж буй боловсролын тэгш хүртээмж, орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллагыг дэмжих, санхүүжилтийг сайжруулах талаарх бодлого хууль тогтоомжтой зөрчилдсөн дээрх зохицуулалтыг шинэчлэн баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-д зөрчлийг арилган зохицуулсан эсэх;

2. 2022-2024 оны хооронд орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллагад суралцсан суралцагчдад олгосон хөнгөлөлтийн хэмжээ, хамрагдсан суралцагчийн тоо, мөн 2025 оноос эхлэн санхүүжүүлээгүй суралцагчдын тоо судалгааг ирүүлэх, тухайн жилд төлөвлөгдсөн атлаа олгогдоогүй санхүүжилтийг юунд зарцуулсан болон нөхөн санхүүжүүлэх эсэх.

Хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу хариуг бичгээр ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ҮҮРИЙНТУЯА

2025000931